



**ГАДААДАД АЯЛЖ БУЙ МОНГОЛ ЖУУЛЧДЫН  
ЗАРДЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА**

*Боловсруулсан: ВЭЗГ, ТТССХ-ийн эдийн засагч Б.Мөнх-Эрдэнэ  
bor@mongolbank.mn*

## ОРШИЛ

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистикт аялал жуулчлалын үйлчилгээтэй холбогдох орлого, зарлагыг үйлчилгээний дэд дансанд бүртгэдэг ба тоон мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2014 оны 1 дүгээр улиралд “Гадаадад аялж буй Монгол иргэдийн зардлын түүвэр судалгаа”-г Монголбанк, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны харьяа Аялал жуулчлалын үндэсний төв, Нийслэлийн аялал жуулчлалын газрууд хамтран зохион байгууллаа.

### 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

#### 1.1 Судалгааны зорилго

Одоогийн байдлаар төлбөрийн тэнцэл дэх аялал жуулчлалын салбарын зардлыг тодорхойлохдоо Монголбанкнаас 2005 онд хийсэн түүвэр судалгааны үр дүнд суурилж, Хил хамгаалах ерөнхий газраас сар бүр гаргадаг “Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын мэдээ”-д үндэслэн тооцоолж байна.

Гэвч сүүлийн жилүүдийн эдийн засгийн өөрчлөлтүүдээс шалтгаалан гадаадад аялсан жуулчны дундаж зардлын хэмжээг 2005 оны судалгааны дүнд суурилах нь учир дутагдалтай тул энэхүү дүнг шинэчлэн тогтоох шаардлагатай болсон.


Иймээс энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол жуулчдын гадаадад аялахдаа зарцуулж буй дундаж зардлыг тооцож, түүнийг үйлчилгээний дансны тооцоололд ашиглахад оршино.

#### 1.2 Түүврийн оновчтой хэмжээ

Судалгаанд түүврийн оновчтой хэмжээг сонгох олон аргачлал байдаг бөгөөд практикт өргөн ашиглагддаг энгийн санамсаргүй түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг хэрхэн сонгох томъёог доор үзүүлэв. Энэхүү түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үздэг.

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Энд,  $t$  = Стьюдентийн  $t$  тархалтын критик утга;  $w$  = түүврийн тодорхой асуултанд хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогмтол хэмжээг ашигладаг;  $N$  = эх олонлогийн хэмжээ;  $\Delta$  = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг  $\Delta$  хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал.



Өгөгдөл:	Утга	Тайлбар
t	1.96	95%-ийн итгэх магадлалын түвшин
w	0.5	тогтмол утга
N	183,029	эх олонлог. 1 жилд аялсан жуулчдын тоо
	0,05	алдааны хягаар
n	384	Оновчтой түүврийн хэмжээ

Түүврийн хамгийн бага оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон эх олонлогийн хэмжээг 2013 онд гадаадад аялсан жуулчдын тоо болох 183,029<sup>116</sup> гэж үзэн тооцоолоход 384 гарч байна.


### 1.3 Түүвэр

Түүвэр судалгааны хүрээнд Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлаас гадаадад аялаад ирсэн Монгол Улсын 697 зорчигч, багцын аялалын үйлчилгээ үзүүлэгч 7 жуулчны компаниас анкетийн аргаар мэдээлэл цуглуулсан. Түүнчлэн 2013 онд Замын-Үүд боомтод хийгдсэн бэлэн валютын судалгаагаар цуглуулсан 324 жуулчны түүврийг дундаж зардлын тооцоололд нэгтгэн боловсрууллаа.

Судалгааны анкетанд<sup>117</sup> жуулчдын талаарх ерөнхий мэдээлэл, аялах хугацаандаа зарцуулсан зардлын талаарх асуултууд орсон.

Хил хамгаалах ерөнхий газраас гаргадаг Монгол Улсын хилээр гарсан жуулчдыг аялсан улс орноор нь ангилж, түүврийн бүтэцтэй харьцуулсан байдлаар Зураг 1-д үзүүлээ. Энэхүү түүвэрлэлтийн бүтэц нь эх олонлогийн бүтэцтэй харьцангуй нийцтэй байгаа тул ангилал тус бүрийнхээ хувьд түүврийн утгууд нь эх олонлогоо төлөөлж чадна гэж үзэж байна.

**Зураг 1: Эх олонлог болон түүврийн бүтцийн харьцуулалт**



<sup>116</sup> Хил, хамгаалах ерөнхий газрын мэдээ.

<sup>117</sup> Судалгааны маягттай хавсралтаас танилцана уу.


## 2. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ҮР ДҮН

### 2.1. Жуулчдын түүвэр судалгааны үр дүн


Судалгаанд хамрагдсан жуулчдын дийлэнхи нь БНХАУ, БНСУ, Япон улсуудад аялсан бөгөөд бусад улс гэсэн ангиллыг ихэвчлэн Тайланд, Энэтхэг, Сингапур, Катар гэсэн Азийн орнууд бүрдүүлж байна. Жуулчдын хүйсийн харьцаа харьцангуй тогтвортой бөгөөд насны бүтцийн дийлэнхийг 30-39 настай хүмүүс эзэлж байна.

Түүвэрт хамрагдсан зорчигчдын 44% нь амралт, аялал жуулчлалын зорилгоор, 32% нь бизнесийн болон албан томилолтоор, 12% нь эрүүл мэндийн үзлэг, эмчилгээнд орох зорилготой байна.


Зураг 2. Жуулчдын нас, хүйсийн бүтэц




Зураг 3. Түүврийн асуулт: Таны аялалын үндсэн зорилго юу вэ?



Зураг 4. Асуулт: Та аялалаа хэрхэн зохион байгуулсан бэ?



Зураг 5. Асуулт: Та аялах хугацаандаа төлбөр тооцоогоо ямар хэлбэрээр хийсэн бэ?



Мөн аялагчдын 13% нь жуулчлалын компаниар дамжуулан, 87% нь өөрөө аялалаа зохион байгуулсан бөгөөд дундаж дүнгээр гадаадад зорчих хугацаандаа хийсэн төлбөр тооцооны 81%-ийг бэлэн мөнгөөр, 19%-ийг карт ашиглан гүйцэтгэдэг гэсэн үр дүн гарчээ. (Зураг 4, 5)

## 2.2. Жуулчдын дундаж зардал<sup>118</sup>

Гадаадад аялж буй Монгол жуулчид аялсан улс бүрийнхээ хувьд ялгаатай зардал гаргадаг бөгөөд энэхүү судалгааны үр дүнд дунджаар **1622 ам.доллар** зарцуулж байна. Аялсан улс орон бүрээр ангилсан дүнг Хүснэгт 1-д үзүүлээ. Энд, АНУ, Канад улсад аялсан жуулчид хамгийн их, ОХУ-д аялагчид хамгийн бага зардал гаргасан байна. Манай улсаас ОХУ-д аялагчдын ихэнхи нь Буриад улс руу Байгаль нуур үзэх, Итгэлт Хамбад бараалхах зорилгоор явдаг нь компаниудаас авсан судалгаанд ажиглагдсан. Иймээс тус улсад зарцуулах дундаж зардал бусад улстай харьцуулбал бага дүнтэй гарчээ. Мөн БНХАУ-д аялагчдын дундаж зардлыг Замын-Үүд боомтоор ба онгоцоор аялсан гэж 2 ангилан тооцоолсон. Онгоцоор аялсан жуулчдын зардлын дүнг энэ удаагийн түүвэр судалгаагаар, харин Замын-Үүд боомтоор зорчсон аялагчдын зардлыг Монголбанкнаас 2013 онд зохион байгуулсан түүвэрлэлтийн үр дүнд үндэслэн тооцоолов.

### Хүснэгт 1 Гадаадад аялсан 1 жуулчны зарцуулах дундаж зардал (ам.доллар)

Улс	30 хүртэл хоног	30-365 хоног
Европ	1,975	2,304
Япон	1,566	2,958
БНХАУ (Буянт-Ухаа)	1,324	2,825
БНХАУ (Замын үүд)	843	
АНУ, Канад	2,230	
БНСУ	1,889	
Бусад	1,416	
ОХУ	515	

Гадаадад аялагчдын зарцуулах дундаж зардлын хэмжээ нь аялах хугацаанаасаа хамааран харилцан адилгүй байдаг тул дундаж зардлын тооцооллыг аялах хугацаагаар нь ангилан гүйцэтгэсэн.

Хил хамгаалах ерөнхий газраас гаргадаг Монгол Улсын тхилээр нэвтэрсэн зорчигчдын мэдээг 30 хүртэл, 30-90, 90-ээс дээш хоногоор аялсан гэж 3 төрлийн ангиллаар мэдээлдэг.

Иймээс түүвэр судалгааны дундаж зардлын үр дүнг аялсан хугацаагаар нь болон аялсан улс орон тус бүрээр нь ангилан тооцооллоо.

### Хүснэгт 2. Аялалын хугацаагаар ангилал

	Нийт жуулчид <sup>^</sup>	Түүвэрлэлтэнд хамрагдсан жуулчид
30 хүртэл хоног	97%	93%
30-аас дээш	3%	7%
<b>Нийт</b>	<b>100%</b>	<b>100%</b>

*ХХЕГ-ын Хилээр зорчигчдын мэдээ*

Түүнчлэн Хүснэгт 2-т үзүүлснээр гадаадад аялагчдын дийлэнхи буюу 97% нь 30-аас бага хоногоор аялдаг бөгөөд судалгааны түүвэрлэлтэн д хамрагдсан аялагчдын 93% нь 30-аас бага хоногоор аялсан үр дүн гарсан. Иймээс АНУ, Канад, БНСУ, ОХУ, бусад улсад 30-аас дээш хоногоор аялсан жуулчдын түүвэрлэлтийн хэмжээ нь дундаж зардлыг тодорхойлох хангалттай хэмжээнд хүрээгүй байна.

Өмнө нь энэ төрлийн түүвэр судалгааг 2005 онд Монголбанкнаас зохион байгуулж байсан бөгөөд үр дүнг Хүснэгт 3-т үзүүлээ. 2014 онд хийгдсэн түүвэр

<sup>118</sup> Эмчилгээ, сургалт, бизнесийн зорилгоор аялсан иргэдийн дүн ороогүй. Зөвхөн жуулчлах зорилготой аялагчдын дундаж зардал.

судалгааны үр дүнг 2005 онтой харьцуулахад Монгол жуулчдын гадаадад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ 3.1 дахин өссөн байна.

### Хүснэгт 3. 2005 оны түүвэр судалгаатай харьцуулсан үр дүн

Түүвэр судалгаа	2005	2014	Өсөлт
1 жуулчны жигнэсэн дундаж зардал	\$ 521	\$1,622	211%

Үүнээс гадна Монголбанкнаас 2013 онд Монгол Улсын хилээр орж, гарч буй бэлэн валютын хэмжээг тооцоолох зорилгоор Чингис хаан нисэх онгоцны буудлаар зорчигчдын дунд түүвэр судалгаа зохион байгуулсан. Эдгээр түүвэрлэлтээс цуглуулсан мэдээллээр нийт болон жуулчлах зорилгоор гарч буй иргэдээс авсан түүврийн дундаж зардлын үр дүнг харьцуулан Хүснэгт 4-т үзүүлээ.


Бэлэн валютын судалгаа дахь жуулчлах зорилготой зорчигчдоос авсан түүврийн хэмжээ 53, бүх зорилгоор гарсан иргэдийн түүвэр 130 гэсэн бага дүнтэй байгаа учраас дундаж зардлын утга нь нийт жуулчдыг төлөөлж чадах шаардлагагүй билээ. Гэсэн хэдий ч эдгээр ижил төстэй түүвэрлэлттэй харьцуулахад манай судалгааны дундаж зардлын дүн нь ойролцоо гарсан байна.

### Хүснэгт 4. Бусад түүврийн үр дүнтэй харьцуулсан хүснэгт

	Жуулчдын зардлын судалгаа - 2014	Бэлэн валютын судалгаа-2013. Жуулчлах зорилготой	Бэлэн валютын судалгаа-2013. Нийт зорчигчид
Дундаж зардал	1,622	1,993	1,674
Түүврийн хэмжээ	375	53	130

Мөн жуулчлах зорилгоор аялсан иргэд өөрийн аялалын зардлын дийлэнхи буюу 30 орчим хувийг дэлгүүрээс худалдаа хийхэд зарцуулдаг байна. Харин БНСУ-д жуулчлах зорилгоор зорчсон иргэд зардлынхаа 56 хувийг эрүүл мэндийн үзлэгт, АНУ, Канад улсад аялагчид зардлынхаа 40%-ийг зочид буудлын төлбөрт төлдөг гэсэн сонирхолтой үр дүн гарчээ. (Зураг 6)

**Зураг 6. Аялалд зарцуулсан зардлын ангилал.**



### 2.3. Компаниудаас авсан судалгааны үр дүн

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хилээр нэвтэрч буй жуулчдаас гадна аяллын үйлчилгээ үзүүлэгч 7 компаниас анкетын аргаар түүвэр авсан. Компаниудаас авсан түүвэрлэлтээр 2012, 2013 онд гадаадад хийсэн багц аяллын мэдээллээс 1 аялагчийн хувьд тухайн улсад зарцуулах дундаж зардлыг тооцоолж<sup>119</sup>, үр дүнг хувь хүмүүсээс авсан түүврийн үр дүнтэй харьцуулан Хүснэгт 5-д үзүүллээ.

Энэхүү харьцуулалтаар хувь хүмүүсээс авсан судалгаа дахь дундаж зардлын хэмжээ нь компаниас авсан түүврийн дунджаас зорчих улс орон тус бүрийнхээ хувьд 225-1587 ам. доллараар илүү байна. Энэ нь тухайн аялагчийн хувьд компанид төлсөн төлбөрөөс гадна хувьдаа зарцуулах халаасны зардалтайгаа явдагтай холбоотой юм. Мөн жуулчдаас авсан түүвэр судалгаанаас үзэхэд ердөө 13% нь жуулчны компаний багц аялалд хамрагдсан учраас компаниас авсан судалгааны үр дүн нь нийт жуулчдын дундаж зардлыг бүрэн илэрхийлж чадахгүй гэсэн үр дүнд хүрсэн.

<sup>119</sup> Нисэх онгоц, галт тэрэг буюу олон улсын тээврийн үйлчилгээний зардал ороогүй бөгөөд зөвхөн гадаадад аялах хугацаандаа зарцуулсан зардал

**Хүснэгт 5. Жуулчдаас болон компаниудаас авсан түүврийн үр дүн. (Ам.доллар)**

	Нисэх буудалд жуулчдаас авсан түүвэр	Компаниас авсан судалгаа	Зорүү	
АНУ-Канад	2,230	2,006	225	10%
БНСУ	1,889	303	1,587	84%
БНХАУ	843-1323	293	550-1030	65%-78%
Бусад	1,416	430	986	70%
Европ	1,975	1,011	964	49%
ОХУ	515	249	267	52%
Япон	1,566	780	786	50%

**ДҮГНЭЛТ**

Энэхүү судалгаагаар гадаадад аялсан Монгол жуулчдын дундаж зардлыг аялсан улс, зорчсон хоног бүрээр, мөн БНХАУ-д аялж буй жуулчдыг гарч буй хилийн боомт тус бүрийнх нь хувьд тооцоолсон нь цаашид төлбөрийн тэнцэл, аялал жуулчлалын статистикийн чанарыг сайжруулах ач холбогдолтой боллоо.

Жуулчдын хувьд зорчсон улс, хугацаанаасаа хамаарч зарцуулсан зардлууд нь харилцан ялгаатай байгаа бөгөөд түүврийн дунджаар 1622 ам.доллар байна. Энэ нь одоогийн төлбөрийн тэнцэлд ашиглагдаж буй 2005 оны судалгааны дундаж зардлаас 3.1 дахин өндөр үзүүлэлт юм.

Мөн жуулчдын 80-аас дээш хувь нь өөрөө аялалаа зохион байгуулдаг бөгөөд аялах үедээ төлбөр тооцоогоо бэлэн мөнгөөр хийдэг. Олон улсын тээврээс бусад зардлынхаа хамгийн өндөр буюу 30 орчим хувийг дэлгүүрийн худалдаанд, харин БНСУ-д зорчих иргэд дийлэнхи хувийг эрүүл мэндийн үзлэгт зарцуулдаг гэсэн үр дүн гарсан.



**ХАВСРАЛТ**

- Түүвэр судалгааны маягт

*Хавсралт.*

*Хувийн жуулчдаас авах судалгааны маягт*

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА**

Монголбанк, Аялал жуулчлалын үндэсний төв, Нийслэлийн аялал жуулчлалын газар нь хамтран Монгол иргэдийн гадаадад аялсан жуулчлалын статистик үзүүлэлтийг сайжруулах зорилгоор энэхүү түүвэр судалгааг зохион байгуулж байна. Энэхүү судалгааг бөглөхөд ойролцоогоор 1 минут зарцуулагдана. Таны өгсөн мэдээллийн нууцлалыг Статистикийн тухай Монгол Улсын хуулийн дагуу чандлан хадгалж, тайланг зөвхөн нэгтгэсэн байдлаар боловсруулах тул та үнэн зөв бөглөнө үү.

**1.** Таны нас?

- a. 19-с доош   b. 20-29   c. 30-39   d. 40-49   e. 50-59   f. 60-с дээш

**2.** Таны хүйс?

- a. эрэгтэй   b. эмэгтэй

**3.** Та аль улсуудад, хэдэн өдөр аялаад ирсэн бэ? /1-ээс олон хариулт сонгож болно/

- |                              |      |                         |                     |
|------------------------------|------|-------------------------|---------------------|
| <b>a.</b> БНХАУ-д .....      | өдөр | <b>e.</b> Япон-д .....  | өдөр                |
| <b>b.</b> ОХУ-д .....        | өдөр | <b>f.</b> Европ-д ..... | /бичнэ үү/.....өдөр |
| <b>c.</b> АНУ, Канад-д ..... | өдөр | <b>g.</b> Бусад ....    | /бичнэ үү/.....өдөр |
| <b>d.</b> Солонгос-д .....   | өдөр | <b>НИЙТ:</b> ..... өдөр |                     |

**4.** Таны аяллын үндсэн зорилго юу вэ? /1-ээс олон хариулт сонгож болно/

- |   |   |
|---|---|
| <b>a.</b> Амралт, аялал жуулчлал                                  | <b>e.</b> Боловсрол /1-ээс дээш жил/    |
| <b>b.</b> Албан томилолт, бизнес / богино хугацааны сургалт орно/ | <b>f.</b> Ажил эрхлэлт /1-ээс дээш жил/ |
| <b>c.</b> Эрүүл мэндийн үзлэг                                     | <b>g.</b> Бусад .....                   |

5. Та аяллаа хэрхэн зохион байгуулсан бэ?
- a. Тур операторын санал болгосон багц аялалд хамрагдсан /асуулт 4 рүү шилжинэ үү/  
b. Аяллаа өөрөө зохион байгуулсан /асуулт 5 руу шилжинэ үү/
6. Та үйлчилгээ авсан тур оператор компанийхаа нэрийг бичнэ үү. ....  
..... ХХК
7. Та аялах хугацаандаа төлбөр тооцоогоо ямар хэлбэрээр хийсэн бэ?
- a. ОУ-ын картаар ..... %-ийг b. Бэлнээр ..... %-ийг
8. Тухайн улсын талаар олж авсан мэдээллийн гол эх үүсвэр нь юу байсан бэ?  
/1-ээс олон хариулт сонгож болно/
- a. Найз нөхөд хамаатан e. Бизнес, албан харилцаа  
b. Аялал жуулчлалын агент, тур оператор ТВ, сонин, сэтгүүл f. Аялал жуулчлалын үзэсгэлэн, яармаг  
c. Жуулчдын гарын авлага, танилцуулга, ном g. Бусад.....  
d. Интернэт, вэб сайт

Та аялах хугацаандаа хэр хэмжээний мөнгө зарцуулсан бэ? Зөвхөн өөртөө зарцуулсан буюу 1 хүний зардлын дүнг дараах хүснэгтэнд бөглөнө үү. (Та зардлынхаа хэмжээг сайн мэдэхгүй байвал ойролцоогоор бичнэ үү.)

A. Олон улсын зорчигч тээврийн зардал	\$ .....
<b>B. Бусад аяллын нийт зардал</b>	\$ .....
/Монгол Улсад ирсэн, явсан тээврийн зардлыг оруулахгүйгээр/	
1. Тур агентлагт төлсөн аяллын төлбөр /зөвхөн багцын аялагч/	\$ .....
2. Хотын аялал: Дэлгүүр, худалдаа /Гар урлал, бэлэг дурсгал/	\$ .....
3. Тээврийн хэрэгсэл, унаа	\$ .....
4. Зочид буудал, байр, жуулчны бааз	\$ .....
5. Хөтөчийн үйлчилгээ	\$ .....
6. Ресторан, хоол	\$ .....
7. Үзвэр үйлчилгээ /хот доторх үзвэрийн газрууд/	\$ .....
8. Эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ	\$ .....
9. Бусад зардал	\$ .....

**СУДАЛГААНД ОРОЛЦСОНД БАЯРЛАЛАА**

**ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ**